# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ...... 2
2 Аудитын тайлан...... 4
2.1. Оршил...... 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ...... 4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ...... 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин...... 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ...... 5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал...... 5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар...... 6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд...... 6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ...... 7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ...... 7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...... 8
2.12. Шилэн дансны мэдээлэл ...... 8
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ...... 8
3 Менежментийн захидал ...... 9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан...... 10
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ...... 10
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ...... 11
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ...... 13
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ...... 15
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ...... 16
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ...... 18
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ...... 19

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ШУТС | Шинжлэх Ухаан Технологийн Сан |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/556
танай ______________-ны № ________________-т

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ П.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, Боловсролын хүрээлэнд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



001590484

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0221SAG3.Docx

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Боловсролын хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал П.Лхагвасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн холбогдох хуулийн дагуу орлогын төлөвлөгөөний талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид 2020 оны 02 дугаар сарын 21-ний дотор хүргүүлэхээр төлөвлөн, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Боловсролын хүрээлэнгийн эрхэм зорилго нь "Боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага болох"-д оршино.

Боловсролын хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах;
- Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын асуудлаар байнгын судалгаа шинжилгээ, туршлага, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх;
- Орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- Бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- Боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах;
- Иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх;

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Боловсролын хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Боловсролын хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд AXPLORER 3.16 программ хангамж ашигладаг байна.

Боловсролын хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Боловсролын хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,913,982.1 мянган төгрөгөөс тооцон 19,139.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд өөрчлөлт ороогүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Боловсролын хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,824.2 мянган төгрөгөөр буюу 11.9% хувиар буурчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 102,672.2 | 5,200.0 | -97,472.2 |
| Урьдчилж гарсан зардал | 26,457.6 | 0 | -26,457.6 |
| Бараа материал | 9,306.7 | 9,670.6 | 363.9 |
| Үндсэн хөрөнгө | 170,355.4 | 268,097.0 | 97,741.6 |
| **Нийт хөрөнгө** | **308,791.9** | **282,967.7** | **-25,824.2** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 308,791.9 | 282,967.7 | -25,824.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **308,791.9** | **282,967.7** | **-25,824.2** |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь “Бага боловсролын шинэчлэл төслийн" санхүүжилтээр 2019 онд Баян-Өлгий аймагт хэрэгжих Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх, сургалтын модуль боловсруулах, казак хэлэнд орчуулах, сургалт зохион байгуулах ажлын санхүүжилт 79,079.4 мянган төгрөг, Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сангийн санхүүжилтээр Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны судалгааны 21,092.7 мянган төгрөг нийт 102,672.2 мянган төгрөгийн тооцоо нийлсний үндсэн дээр авлагад тусган татан төвлөрүүлсэн байсан.

2019 онд ажлын гүйцэтгэл гарч бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд ШУТС-ийн 2020 хүртэл хэрэгжих 21-р зууны суралцагчийн цогц чадамжийн судалгааны томилолтын зардал 5,200.0 мянган төгрөгийг төрийн сангийн мэргэжилтэнтэй тооцоо нийлж авлагаар тусгажээ.

Урьдчилж гарсан зардал 26,457.6 мянган төгрөгөөр буурсан нь 2018 оноос 2019 онд хэрэгжиж дуусах Монголын үндэсний телевизтэй байгуулсан Боловсрол асуудал шийдэл нэвтрүүлэг хийх ажлаар явах онгоцны зардал урьдчилж шилжүүлж тайлант онд ажлын гүйцэтгэл гарсан тул үлдэгдэлгүй болсон байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 9,306.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант жилд 1,660.9 мянган төгрөгийн бичиг хэрэг, хангамжийн материал худалдан авч, 1,297.0 мянган төгрөгийг зарцуулж, эцсийн үлдэгдэл 9,670.6 мянган төгрөг болжээ.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 170,355.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант жилд 97,741.6 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 тогтоолоор БХ/201911001 тоот тендер зарлаж, бага оврын автобус, компьютер, бусад тоног төхөөрөмж худалдан авснаас хөрөнгө нэмэгдсэн байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв тайлагнасан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьдог.

Боловсролын хүрээлэнгийн үндсэн чиг үүргийн үйл ажиллагаанд зориулж тайлант хугацаанд нийт 1,149,734.0 мянган төгрөгийг баталснаас 1,144,665.1 мянган төгрөгийг зарцуулж, 5,068.9 мянган төгрөгийг хэмнэснээр зардлын гүйцэтгэл 99.6 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Боловсролын хүрээлэн нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 4,000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан боловч биелэгдээгүй байна.

**Нэмэлт төсөв:** Боловсролын тухай хуулийн 16.1-р заалт, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/169 дүгээр тушаалын дагуу боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд дараах орлогыг нэмэлтээр бүрдүүлсэн байна. Үүнд:

- НҮБ-ын Хүүхдийн сангийн төслөөс 37,532.3 мянган төгрөг;
- Дээд боловсролын чанарын шинэчлэл төсөл, Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх төсөл, Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл, ЭМЯ-ны Глобаль сангийн төслүүдээс 277,537.0 мянган төгрөг;
- ШУТС-аас нийт 454,247.5 мянган төгрөг;

Нийт 769,316,9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, төсөл хөтөлбөрт зарцуулж, ШУТС-ийн 2020 онд үргэлжлэн хэрэгжих төслийн 5,200.0 мянган төгрөгийг авлагад тусган тус тус төвлөрүүлжээ.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн материаллаг бус алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар зөвлөмжийн биелэлтийг шалгаж ажиллана.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Боловсролын хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант жилд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

## 2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсролын хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Боловсролын хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Орлогын данстай холбоотой асуудал*

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*
Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг 4,000.0 мянган төгрөгөөр баталсан боловч төлөвлөгөө биелэгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчиж байна.

*<u>Эрсдэл:</u>*

Орлогын төлөвлөгөө биелүүлээгүй байх;

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах;

*1.3. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

Зөвлөмжийг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **138,436,501.00** | **14,870,630.00** |
| **33** | **АВЛАГА** | 102,672,171.00 | 5,200,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 5,200,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 102,672,171.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 102,672,171.00 | 00.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 26,457,600.00 | 00.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 26,457,600.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 9,306,730.00 | 9,670,630.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,306,730.00 | 9,670,630.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,297,000.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,731,430.00 | 4,731,430.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,278,300.00 | 4,939,200.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **170,355,398.36** | **268,097,030.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 170,355,398.36 | 268,097,030.48 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 165,355,398.36 | 264,097,030.44 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 69,500,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 229,421,037.00 | 304,151,847.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -146,801,284.80 | -179,804,436.20 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 110,512,042.00 | 110,512,042.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,776,395.84 | -40,262,422.36 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,000,000.00 | 4,000,000.04 |
| 39301 | Програм хангамж | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,000,000.00 | -1,000,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -999,999.96 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **308,791,899.36** | **282,967,660.48** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **00.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **308,791,899.36** | **282,967,660.48** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 308,791,899.36 | 282,967,660.48 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 96,015,446.35 | 96,015,446.35 |
| 51101 | Өмч: - төрийн | 96,015,446.35 | 96,015,446.35 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 212,776,453.01 | 186,952,214.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 212,776,453.01 | 212,776,453.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -25,824,238.88 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **308,791,899.36** | **282,967,660.48** |

## 4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,740,623,203.00** | **1,818,443,936.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,240,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,240,000.00 | 00.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,240,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,240,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,730,383,203.00** | **1,818,443,936.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,109,955,800.00 | 1,145,734,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,109,955,800.00 | 1,145,734,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 620,427,403.00 | 672,709,936.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 208,726,226.00 | 37,532,336.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 403,401,177.00 | 460,312,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,300,000.00 | 174,864,850.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,533,574,753.92** | **1,844,268,174.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,533,574,753.92** | **1,844,268,174.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,511,043,649.19 | 1,833,034,141.63 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 558,669,272.00 | 654,901,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 446,511,900.00 | 517,939,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 75,285,172.00 | 100,090,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,872,200.00 | 36,872,200.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,510,705.34 | 81,416,451.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,613,500.00 | 58,645,251.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,103,000.00 | 5,914,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,371,720.00 | 4,337,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 272,700.00 | 690,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,149,785.34 | 11,829,100.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 10,387,730.00 | 202,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 00.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 00.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 00.00 |
| 210304 | Байрны түрээс | 10,387,730.00 | 202,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,660,249.93 | 44,400,427.17 |
| 210401 | Бичиг хэрэг | 23,318,250.00 | 29,698,176.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,554,499.93 | 8,860,621.17 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,475,000.00 | 1,529,130.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,312,500.00 | 4,312,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 38,902,714.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 38,902,714.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 31,202,426.00 | 49,446,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 31,202,426.00 | 49,446,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 516,311,578.00 | 643,993,807.77 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 511,311,578.00 | 643,993,807.77 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 249,398,973.92 | 358,673,454.88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 212,509,455.00 | 312,184,277.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 36,889,518.92 | 46,489,177.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,531,104.73 | 11,234,033.25 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 9,300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 9,300,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 22,531,104.73 | 1,934,033.25 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,531,104.73 | 1,068,854.25 |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | | 865,179.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **207,048,449.08** | **-25,824,238.88** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **207,048,449.08** | **-25,824,238.88** |

## 4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,731,383,203.00** | **1,921,116,107.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,000,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,730,383,203.00** | **1,921,116,107.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,109,955,800.00 | 1,145,734,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,109,955,800.00 | 1,145,734,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 620,427,403.00 | 775,382,107.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 208,726,226.00 | 37,532,336.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 403,401,177.00 | 460,312,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,300,000.00 | 277,537,021.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,627,548,606.00** | **1,776,885,297.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,627,548,606.00** | **1,776,885,297.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,502,345,330.27** | **1,760,451,263.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 558,669,272.00 | 654,901,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 446,511,900.00 | 517,939,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 75,285,172.00 | 100,090,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,872,200.00 | 36,872,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,510,705.34 | 81,416,451.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,613,500.00 | 58,645,251.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,103,000.00 | 5,914,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,371,720.00 | 4,337,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 272,700.00 | 690,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,149,785.34 | 11,829,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 10,387,730.00 | 202,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 10,387,730.00 | 202,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,199,249.93 | 43,103,427.17 |
| 210401 | Бичиг хэрэг | 22,857,250.00 | 28,401,176.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,554,499.93 | 8,860,621.17 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,475,000.00 | 1,529,130.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,312,500.00 | 4,312,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 39,902,714.00 | 1,660,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,000,000.00 | 1,660,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 38,902,714.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 34,360,026.00 | 46,289,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 34,360,026.00 | 46,289,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 540,606,178.00 | 620,893,807.77 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 535,606,178.00 | 620,893,807.77 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 212,709,455.00 | 311,984,277.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 212,709,455.00 | 311,984,277.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **125,203,275.73** | **16,434,033.25** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 9,300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 9,300,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 125,203,275.73 | 7,134,033.25 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 125,203,275.73 | 1,068,854.25 |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,065,179.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **103,834,597.00** | **144,230,810.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **103,834,597.00** | **144,230,810.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **103,834,597.00** | **144,230,810.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 103,834,597.00 | 144,230,810.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 103,834,597.00 | 144,230,810.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-103,834,597.00** | **-144,230,810.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,015,446.35** | | **212,776,453.01** | 308,791,899.36 |
| | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | | 00.00 | 00.00 |
| | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **96,015,446.35** | | **212,776,453.01** | 308,791,899.36 |
| | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | | 00.00 | 00.00 |
| | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | | 00.00 | 00.00 |
| | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | | 00.00 | 00.00 |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | | 00.00 | 00.00 |
| | Тайлант үеийн үр дүн | 00.00 | | -25,824,238.88 | -25,824,238.88 |
| | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,015,446.35** | | **186,952,214.13** | 282,967,660.48 |

## 4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,149,734,000.00 | 1,144,665,145.75 | -5,068,854.25 | 99.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,149,734,000.00 | 1,144,665,145.75 | -5,068,854.25 | 99.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,140,434,000.00 | 1,135,365,145.75 | -5,068,854.25 | 99.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 654,901,200.00 | 654,901,200.00 | 00.00 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 517,939,000.00 | 517,939,000.00 | 00.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 100,090,000.00 | 100,090,000.00 | 00.00 | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,872,200.00 | 36,872,200.00 | 00.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 82,328,400.00 | 81,416,451.81 | -911,948.19 | 98.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,670,000.00 | 58,645,251.81 | -24,748.19 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,914,600.00 | 5,914,600.00 | 00.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,731,700.00 | 4,337,300.00 | -394,400.00 | 91.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,183,000.00 | 690,200.00 | -492,800.00 | 58.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,829,100.00 | 11,829,100.00 | 00.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 392,000.00 | 00.00 | -392,000.00 | 0.0 |
| 210304 | Байрны түрээс | 392,000.00 | 00.00 | -392,000.00 | 0.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,803,000.00 | 27,551,711.17 | -251,288.83 | 99.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,850,000.00 | 12,849,460.00 | -540.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,054,500.00 | 8,860,621.17 | -193,878.83 | 97.9 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,586,000.00 | 1,529,130.00 | -56,870.00 | 96.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,312,500.00 | 4,312,500.00 | 00.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 142,500,000.00 | 142,499,710.00 | -290.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 142,500,000.00 | 142,499,710.00 | -290.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,169,200.00 | 1,161,000.00 | -8,200.00 | 99.3 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,169,200.00 | 1,161,000.00 | -8,200.00 | 99.3 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 205,040,200.00 | 201,535,077.77 | -3,505,122.23 | 98.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 201,540,200.00 | 201,535,077.77 | -5,122.23 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,500,000.00 | 00.00 | -3,500,000.00 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,300,000.00 | 26,299,995.00 | -5.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 26,300,000.00 | 26,299,995.00 | -5.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,300,000.00 | 9,300,000.00 | 00.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,300,000.00 | 9,300,000.00 | 00.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,300,000.00 | 9,300,000.00 | 00.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,149,734,000.00 | 1,144,665,145.75 | -5,068,854.25 | 99.6 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,145,734,000.00 | 1,144,665,145.75 | -1,068,854.25 | 99.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,145,734,000.00 | 1,144,665,145.75 | -1,068,854.25 | 99.9 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 4,000,000.00 | 00.00 | -4,000,000.00 | 0.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 00.00 | -4,000,000.00 | 0.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 51 | 51 | 0 | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 49 | 49 | 0 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | 0 | |

## 4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 775,382,107.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 775,382,107.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 775,382,107.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 202,000.00 |
| 210304 | Байрны түрээс | | 202,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 15,551,716.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 15,551,716.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 3,392,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 3,392,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 45,128,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 45,128,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 419,358,730.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 419,358,730.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 285,684,282.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 285,684,282.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,065,179.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 775,382,107.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 775,382,107.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 37,532,336.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 460,312,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 277,537,021.00 |

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2020 | Аудитын нэр: | ***Боловсролын хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: САГ-2020/171/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Боловсролын хүрээлэн** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог, нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг 4,000.0 мянган төгрөгөөр баталсан боловч төлөвлөгөө биелэгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчиж байна. | 4,000.0 | Зөвлөмж өгөх | Захирал,<br>Нягтлан бодогч | П.Лхагвасүрэн<br>Б.Цэрэнханд |